

Иосеф Смитийн дараа хэнийг дагах талаар

Бошиглогч Иосеф Смит нас барахынхаа өмнө Арван хоёр төлөөлөгчийн чуулгад ийн заажээ.



'Ах нар аа, . . . Чухал үйл явдал ойрын үед тохиох болно. Дайснууд миний амийг хөнөөж болзошгүй. Тэгсэн тохиолдолд, надад байгаа түлхүүрүүд болон хүчийг та нарт шилжүүлж өгөхгүй бол, тэдгээр нь дэлхийгээс алга болно. Харин

би түлхүүрүүд болон хүчийг та нарын тэргүүн дээр шилжүүлж өгсөн тохиолдолд Бурхан үүнийг зөвшөөрч байгаа бол, би алуурчдын гарт хохирогч болон унах нь хамаагүй хэрэг. Тэгвэл, миний ажил хийгдэж дууссан юм байна, цаг хугацааны бүрэн байдлын энэ эрин үед байгуулагдах ёстой Бурханы хаант улсын суурь тавигдсан юм байна гэдгийг мэдээд би баяр баясал, сэтгэл ханамжтайгаар энэ амьдралыг орхих болно.


Одооноос эхлэн энэ Сүмийг удирдах үүрэг өөрсдийгөө залгамжлах бусад хүнийг томилох хүртэл Арван хоёрын мөрөн дээр ирлээ. (Сүмийн ерөнхийлөгчдийн сургаалаас: Иосеф Смит [2007], 603–604)

Мөн Тэргүүн зөвлөл бол Арван хоёр төлөөлөгчийн чуулгын дээрх цорын ганц бүлэг боловч бошиглогчийг нас барахад Тэргүүн зөвлөл тарна гэж Иосеф Смит заасан (History, 1838–1856 [Manuscript History of the Church], volume B-1, 691, josephsmithpapers.org-г үзнэ үү).

- Өмнө тавьсан гурван шаардлагад хариулахад та нарын сурсан ямар зүйл туслах вэ?
- Их Эзэн бошиглогчийг нас барах үед Түүний Сүмийн удирдлагыг үргэлжлүүлэх ямар загварыг тогтоосон бэ?

Бригам Янгийг томоохон цуглаан дээр гэгээнтнүүдэд хандан үг хэлэхэд олон хүн ер бусын туршлагыг гэрчилж, Ариун Сүнсний баталгааг мэдэрчээ.

Хожим нь Тэргүүн зөвлөлд үйлчилж байсан ерөнхийлөгч Жорж К.Каннон (1827–1901) дараах зүйлийг хуваалцсан.



Бригам Янг . . . босоод, хүмүүст хандан ярив. . . . Тэрхүү үйл явдалд оролцсон хүмүүс өөрсдөдөө төрсөн сэтгэгдлээ мартаж үл чадна! Хэрэв Иосеф үхлээс босож ирээд, тэдний нүдэн дээр ярьсан бол тэр уулзалтад

оролцсон олон хүнд үзүүлсэн нөлөөний дэргэд тийм ч цочирдом хэрэг болохгүй байсан биз. Энэ нь Иосефын өөрийнх нь дуу хоолой байсан. Мөн зөвхөн Иосефын дуу хоолойг сонсоод ч зогссонгүй хүмүүсийн нүдэнд Иосеф бие хүнээрээ яг л тэдний өмнө зогсож буй мэт санагджээ. Тэр өдөр тэрхүү цугларалт дээр болсноос илүү гайхамшигтай, ер бусын үйл явдлыг бид хэзээ ч сонсож байгаагүй. Их Эзэн өөрсдийг нь удирдахаар сонгогдсон түүнд эргэлзэх аргагүй болтол өөрийн хүмүүст гэрчлэл үлдээсэн. Тэд нүдээрээ харж, чихээрээ сонссон. Дараа нь Бурханы итгүүлэх хүчээр хэлсэн үгс тэдний зүрхэнд хүрч, тэд Сүнсээр дүүрч, асар их баяр хөөрт автаж байлаа. Уйтгар гуниг оршиж байсан, зарим хүний зүрх сэтгэлд эргэлзээ, тодорхой бус байдал байсан байх. Харин одоо Иосефын оронд тэдний дунд үйлдэх шаардлагатай эрх мэдлийг Их Эзэнээс олгосон хүн энд байгаа нь бүгдэд ойлгомжтой байлаа (George Q. Cannon, "Joseph Smith, the Prophet," *Juvenile Instructor*, Oct. 1870, 174–75).

Бригам Янгийг гэгээнтнүүдэд хандан үг хэлэх үед тэнд байсан гишүүн Эмили Смит Хойт ийн тэмдэглэжээ.

Түүний тайлбарлаж байгаа байдал, нүүрний хөдөлгөөн, дуу хоолой миний бүхий л биеийг цочроов. Миний бие алагдсан Иосефын биеийг өөрийн нүдээр үзсэн. Түүний эрхэм магнайд хүрэхэд гарт минь үхлийн цэв хүйтэн мэдрэгдэж байсан. Би Иосеф Смитийн нас барсныг мэдэж байсан. Тэгсэн хэдий ч би байн байн түүнийг Иосеф мөн үү хэмээн гайхаж, индэр рүү өөрийн эрхгүй харж билээ. Гэвч тэр Иосеф Смит биш, харин Бригам Янг байсан. Хэрэв хэн нэгэн Бригамыг гэгээнтнүүдийн үйл хэргийг зохицуулах эрхтэй гэдэгт эргэлзэж байвал би тэдэнд ингэж хэлнэ. Бурханы сүнснийг авч, өөрсдөө мэд. Их Эзэн өөрөө хангах болно (Emily Smith Hoyt, in Lynne W. Jorgensen, "The Mantle of the Prophet Joseph Passes to Brother Brigham: A Collective Spiritual Witness," *BYU Studies*, vol. 36, no. 4 [1996–1997], 164).

- Хэрэв та нар тэнд байсан бол энэ туршлага та нарт хэрхэн нөлөөлөх байсан гэж бодож байна вэ?
- Моронай 10:5 нь та нарын судалсан зүйлтэй ямар холбоотой байж болох вэ?